

ГАРЧИГ

1. Оршил.....	1
2. Өлзийт тээлийн алтны шороон ордын товч танилцуулга.....	2
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	5
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	7
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	8
6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	8
6.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	9
6.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
6.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	12
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	16
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
14. Тухайн жилийн байгаль орчны хамгаалах төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нөлөөлөлийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	25
15. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын нийт зардлын хэмжээ.....	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	6
Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	8
Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	9
Хүснэгт 4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
Хүснэгт 5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
Хүснэгт 8. Осол, Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
Хүснэгт 11. Тухайн жилийн БОХМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
Хүснэгт 12. Тухайн жилийн БОХМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	25
Хүснэгт 13. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын нийт зардал.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ордын байршил.....	2
Зураг 2. Ордын сансарын зураг.....	2
Зураг 3. Ажилчдын хотхон.....	4
Зураг 4. Уурхайн оффис.....	4

1. Оршил

Өлзийт тээлийн алтны шороон ордод анх 1998-1999 онуудад “Монгол газар” ХХК эрэл, хайгуулын ажил хийж ордын нөөцийг С₁, С₂ зэргээр тогтоосон байдаг. Улмаар ордод олборлолтын үйл ажиллагааг 1999 оноос эхлэн 2008 он хүртэл “Монгол газар” ХХК болон “Алтан дорнод Монгол” ХХК олборлолтын ажлыг явуулсан байна.

2008 оноос Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдсантай холбогдуулан тус ордод олборлолт явуулах боломжгүй болсон бөгөөд 2016 оноос дээрх хуулийн дагаж мөрдөх журмаар олборлолт явуулж эхлэсэн болно.

2015 оны 08 сарын 14-ний өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 626 тоот шийдвэрээр MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг “Алтан дорнод Монгол” ХХК-иас “Бат бродерс” ХХК-д шилжүүлсэн байна.

“Бат бродерс” ХХК нь 1999 онд “Монгол газар” ХХК-ийн боловсруулсан эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг үндэслэл болгож мөн 2007-2008 онуудад “Алтан дорнод Монгол” ХХК-ийн хийсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнг үндэслэн 2015 онд ордын нөөцийг шинэчилэн тодотгож алтны бодитой (В) нөөцийг 442.5 кг, боломжтой (С) нөөцийг 3.9 кг-р тус тус тогтоож улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

2015 оны 11 сарын 02-ны өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 952 тоот шийдвэрээр MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг “Бат бродерс” ХХК-аас “БМНС” ХХК-д шилжүүлсэн байна.

“БМНС” ХХК Өлзийт тээлийн уурхайн Өлийн гол, Өлзийт тээлийн дээд хэсэг гэсэн уурхайн үндсэн 2-н хэсэгт ашиглалтыг явуулхаар төлөвлөж байна. Төслийн уурхайг ашиглах гүн дунджаар 18.0м.


Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 167.7 мян.м³ элс олборлох бөгөөд авто тээвэртэй ашиглалтын системээр үйл ажиллагаагаа явуулна.

2. ӨЛЗИЙТ ТЭЭЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

MV-001410 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 500 км, Архангай аймгийн Цэнхэр сумаас урагш 70 км тус тус зайтай оршино. Цэнхэр сумаар Монгол улсын хэвтээ тэнхлэгийн Улаанбаатар-Архангай чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Талбайн номенклатур М-47-48, ордын байрлалыг дараах зурагт үзүүлэв.

Ордын байршил

Зураг. 1



Ордын байршилийн сансрын зураг

Зураг. 2



Өлзийт тээлийн алтны шороон ордод анх 1998-1999 онуудад “Монгол газар” ХХК эрэл, хайгуулын ажил хийж ордын нөөцийг тогтоосон байдаг. Улмаар ордод олборлолтын үйл ажиллагааг 1999 оноос эхлэн 2008 он хүртэл “Монгол газар” болоод “Алтан Дорнод Монгол” ХХК олборлолтын ажлыг явуулсан байдаг.

2008 оноос Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдсантай холбогдуулан тус ордод олборлолт явуулах боломжгүй болсон байдаг. 2015 оны 11 сарын 02-ны өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 952 тоот шийдвэрээр MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг “Бат бродерс” ХХК-аас “БМНС” ХХК шилжүүлэн авч 2016 оноос тус тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж эхлэсэн.

2016 онд “БМНС” ХХК MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авах үед өмнөх компаниудын үйл ажиллагааны улмаас 280 гаруй га талбай уурхайн нөлөөлөлд өртсөн байдаг. “БМНС” ХХК 2016 оноос тус тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулахад 38 га талбай уурхайн нөлөөлөлд өртсөн байна. Манай компани 2016 оноос нөхөн сэргээлтийн ажлыг шат дараалалтайгаар гүйцэтгэж 2021 оны эцсийн байдлаар 190.1 га талбайд техник, 102.8 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих стандартын дагуу гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгөөд байна.

2022 оны нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөнд 10 га талбайд техник, 8 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд тухайн оны гүйцэтгэлээр техникийн нөхөн сэргээлт 10 га, биологийн нөхөн сэргээлт 8 га талбайд хийгээд байна.

Уурхайн барилга байгууламжууд: Өлзийт тээлийн уурхай нь 2016 онд уурхайн ашиглалтын ажлыг эхлүүлж уурхайд бүтээн байгуулалтыг хийгээд байна. Уурхайн талбайд ажилчдын амьдрах гэр, оффисын байр, цайны газар, засварын цех, хамгаалалтын албаны байр, агуулах /ил агуулах, сэлбэг материалын агуулах/-ын байгууламж, ШТС, элс угаан баяжуулах цех, цэвэр бохирын нуурууд, гүний худгууд, ус цуглуулах далан зэрэг уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай байгууламжуудыг барьж байгуулан ашиглаж байна.

Ажилчдын хотхон

Зураг 3



Уурхайн оффис

Зураг 4



3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Архангай аймаг

Архангай аймаг нь 55 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 19 сум, 99 багтай. Хамгийн том газар нутагтай сум болох Ихтамир сум нь 4.8 мянган км² нутаг дэвсгэртэй бол аймгийн төв Эрдэнэбулган сум нь 0.5 мян.км² буюу хамгийн жижиг газар нутагтай юм.

Хүн ам:

Архангай аймаг нь 96.7 мянган хүн амтай, 27.8 мянган айл өрхтэй. Нийт хүн амын 49.9 хувь нь эрэгтэй, 50.1 хувь нь эмэгтэйчүүд тус тус байна.

Дэд бүтэц:

Аймгийн хэмжээнд 1083 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас ХАА, агнуурын чиглэлээр 114, боловсруулах чиглэлээр 104, барилгын чиглэлээр 34, бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр 325 гэх мэт олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Архангай аймаг нь төвийн эрчим хүчний систем, хатуу хучилттай авто замд холбогдсон, өндөр хурдны шилэн кабел, тоон системийн радио шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй, нийтийн хямд тээврийн хэрэгсэлтэй, хүмүүсийн амьдралын өртөг багатай зэрэг давуу талуудтай.

Эдийн засгийн байдал:

Архангай аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд газар тариалан, аялал жуулчлал, уул уурхай эрчимтэй хөгжиж байна. Архангай аймаг хангайн бүсийн жуулчдын нэгэн чухал зорих газрын нэг болсноор тус аймгийн нутагт одоогоор 24 жуулчны бааз, 5 зочид буудал, 1 аялал жуулчлалын цогцолбор, 2 рашаан сувилал үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд бүх сумд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон ба аймгийн нутаг дэвсгэрт Mobicom, Skytel, Unitel, G-Mobile болон цахилгаан холбооны үүрэн телефонтой.

Цэнхэр сум

Цэнхэр сум нь Хангайн уулархаг муж хийгээд Орхон, Тамирын хөндийд оршдог бөгөөд хойд талаараа Эрдэнэбулган, Батцэнгэл сумтай баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, өмнөд талаараа Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Бүрд сумтай, зүүн өмнө зүүн талаараа өөрийн аймгийн Төвшрүүлэх, Хотонт сумтай хиллэн оршино. Нутаг дэвсгэрийн хувьд 332.8 мянган га талбайтай. Цэнхэр сумын нийт 5.4 мянган хүн амтай, 152 мянган толгой малтай, Улаанбаатар-Архангай

чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг, 35 кВт-н цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдсон дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн сум юм.

Цэнхэр суманд 12 жилийн дунд сургууль, хүн, мал эмнэлгийн салбар, цэцэрлэг, соёл урлагийн цогцолбор, халуун ус, үсчний газар, худалдаа үйлдвэр үйлчилгээний цэгүүд, газар тариалангийн чиглэлийн компани, хоршоо, нөхөрлөл, ХААН Банк, холбооны салбар зэрэг аж ахуй нэгж тус тус ажилладаг байна.

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“БМНС” ХХК-ийн “Өлзийт тээлийн” алтны шороон орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг энэхүү бүлэгт хам бүрдэл тус бүрээр нь төслийн технологитой уялдуулан тодорхойлсон бөгөөд нөлөөллийг тодорхойлохдоо нөлөөллийн хэлбэр, шууд, шууд бус эсэх, дараалал, буцалттай, буцалтгүй эсэх, хугацаа зэргийг магадлан жагсаах аргыг (checklist) /Р.Мижиддорж, 2002 он/ ашигласан тодорхойлж хүснэгтээр үзүүлэв.

Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 1

Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	Өөрөө зохицуулах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцалттай	Буцалтгүй
Байгалийн экосистемийн өөрчлөлт								
Шатах тослох материалын хэрэглээтэй холбоотойгоор газрын доорх усны чанарт өөрчлөлт орох	N	Y	N	N	Y	N	Y	N
Дотоод зам тээвэрлэлтээс ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	Y	N	N	N	N	Y	Y	N
Уурхайн ухаш, хөрсний овоого болон бусад объектоос ургамлын бүлгэмдэлд үзүүлэх нөлөөлөл	Y	N	N	N	N	Y	Y	N
Уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлтээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	Y	N	N	N	N	Y	N	Y
Машин техникийн зорчих хөдөлгөөн, дуу чимээ газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох тоосжилт зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	Y	N	N	N	Y	Y	Y	N
Хөрс хуулалтын үед нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, шувуудын үүр сүйтгэх	Y	N	N	N	Y	Y	N	Y
Байгалийн нөөц, ашиглалт								
Газрын гадаргын нөөц баялаг	Y	N	N	N	N	Y	N	Y
Бэлчээрийн байдал	Y	N	N	Y	N	N	Y	N
Ундны усны чанар	N	N	N	N	N	N	N	N
Ургсгал усны хэрэглээ	Y	N	N	Y	N	N	N	Y
Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтаас үүсэх хорт хийн агаар орчинд үзүүлэх нөлөөлөл	Y	N	N	Y	N	N	Y	N
Уурхайн ухаш болон овоолгоос үүсэх тоосонцор	Y	N	N	Y	N	N	Y	N

Гадаад тээвэрлэлтээс агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Y	N	N	Y	N	N	Y	N
Шатах тослох материалын хэрэглээтэй холбоотойгоор хөрсний чанарт гарч болзошгүй	Y	N	N	Y	N	N	Y	N
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх	Y	N	N	Y	N	N	Y	N
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, архелоги, палентлогийн олдвор								
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	Y	N	N	N	N	Y	N	Y
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	Y	N	N	N	N	Y	N	Y
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
Түүх соёлын дурсгалд нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
Археологи, палентлогийн олдворт нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
Эдийн засаг, нийгмийн асуудал								
Хувийн болон татварын орлого өөрчлөгдөх	Y	N	N	Y	N	N	Y	N
Орон нутгийн орлого нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	Y	N	N	Y	N	N	Y	N
Ажлын байр нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	Y	N	N	Y	N	N	Y	N
Бусад нөлөөлөл								
Ахуйн бохир ус хөрсөнд нэвчих, хөрсний ус бохирдох	N	Y	N	N	Y	N	Y	N
Ахуйн хатуу хог хаягдлын цэгийн ариутгал, халдваргүйжүүлэлт муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	N	N	N	Y	N	N	Y	N

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Өлзийт тээлийн алтны шороон орд ашиглах уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Газар Чандмань” ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол улсын багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: MV-001410 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа олборлолтын талбай, нөхөн сэргээлтийн талбай, барилга байгууламжууд болон удирдлагын багийн ажилладаг хотын оффисыг хамруулан ойлгоно.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөлийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хүснэгт 2

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрс хуулалт, элс олборлолт, элс тээвэрлэлт, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсч агаарын чанарт сөргөөр нөлөөлж, улмаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Уурхайн тээвэрлэлтийн замуудыг дулааны улиралд усалгаа хийж чийгшүүлж байх, 10м/с дээш салхитай үед уулын ажлыг түр хугацаанд зогсоох	Уурхайн талбай, элс зөөвөрлөх болон шаардлагатай тохиолдолд карьерийн зам талбайд	Нэгж усалгаа	13166.0	90	1,185.0	Зуны 3 сард	Монгол Улсын Агаарын тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанарын стандарт – Техникийн ерөнхий шаардлага. MNS5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.Техникийн ерөнхий шаардлага” MNS ISO4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS6063:2010, “Агаарын чанар, хот
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдын хязгаар тогтоож тэмдэг тэмдэглэгээ байршуулах, олон салаа зам гаргахгүйн тулд замын маршрут гаргаж, тэмдэгжүүлэн ажилчидад мэдээллэн таниулах	Төслийн талбайн бүх зам талбайд	Км Мотоцаг	15000.0	15	225.0	Улиралд тутамд	“Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.Техникийн ерөнхий шаардлага” MNS ISO4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS6063:2010, “Агаарын чанар, хот

3	Ахуйн гаралтай хог хаягдал нь ялзарч муудан агаарт эвгүй үнэр гарган агаар орчинг бохирдуулна	Ахуйн хатуу шингэн хаягдлыг битүүмжилж, ялган ангилж хаях, мөн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулах.	Кемпийн түр хог хаягдлын цэг	Үнэрийн бохирдолын хэмжээ	-	-	-	Сар бүр	суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990:2000, “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”
Нийт							1,417.0		

6.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд үйл ажиллагааны явцад газрын хэвлий, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

Хүснэгт 3

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Засварын газар болон шатахуун түгээх газарт шатах тослох материал асгарах	Бензин тос маслыг битүүмжлэл сайтай газар хадгалах	Засварын төв, уурхайн карьер, шатахуун түгээх станц	Литр	500000.0	1	500.0	Жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд	MNS3297:1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм” MNS5850:2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн
2	Газар хөндөх, Хөрсөн бүрхэвч хуулах	Хөрс хуулах ажлын өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг хэмжиж зөв хадгалах, бүртгэл хөтөлж хаягжуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Хөрс хуулах талбайн тоо хэмжээ	-	Газар хөндөх, хөрс хуулах тухай бүрт	-	Уурхайн үйл ажиллагаа явагдах хугацаанд шаардлагатай	

								тохиолдол бүрт	зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5914:2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт” MNS5919:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
3	Хуулсан шимт хөрс салхи, усаар зөөгдөж механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, чийгээ алдах	Шимт хөрсийг усаар зөөгдөхөөс хамгаалж зөв талбайд хадгалах, нэг наст ургамал тарьж хөрсийг бэхжүүлэх, хөрсний хэмжилт хийж хаягжуулах	Уурхайн талбайд	м ³	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	Шимт хөрс хуулах тухай бүрт	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	Шаардлагатай тохиолдолд	
	Нийт						500.0		

6.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад гадаргын болон гүний усанд бохирдол үүсэхээс сэргийлж дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллана.

Хүснэгт 4

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усны зүй зохисгүй хэрэглээг арилгах	Усыг ариг гамтай хэрэглэх, усан орчиныг хэрхэн хайрлан хамгаалах тухай нийт ажилчдад сургалт орох	Нийт ажилчид	Сургалтын бүртгэл	-	4	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Улирал тутам	Усны тухай хууль, Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
2	Гүний усны нөөц хомсдох	Гүний усны нөөц хомсдохоос сэргийлж	Баяжуулах	м ³	Үйл ажиллагааны	Шаардлагатай тохиолдол	Үйл ажиллагааны	Шаардлагатай тохиолдол	MNS4596:1998

	гадаргын усыг хуримтлуулах, тоосжилт дарах зорилгоор замын усалгаанд ашиглах	хэсэг, Уулын хэсэг		зардалд тусгагдсан	бүрт	зардалд тусгагдсан	бүрт	
--	--	-----------------------	--	--------------------	------	--------------------	------	--

6.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ан амьтан, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүснэгт 5

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагаанаас ойролцоох уст цэг бохирдох, усны нөөц хомсдох, ан амьтан усаар гачигдах	Төсөл хэрэгжих талбайн ойролцоо орших уст цэгийг бохирдуулахгүй байх, усны нөөцийг хомсдохоос сэргийлж, ан амьтан усаар гачигдахаас хамгаалах арга хэмжээг тухай бүрт нь хэрэгжүүлнэ	Нийт ажилчид	Усны шинжилгээ	45000.0	4	180.0	Улирал тутам	Амьтны тухай хууль
2	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөс зэрлэг мал амьтан үргэж дайжих	Тээврийн хэрэгслийг тодорхой маршрутын дагуу явуулж, ан амьтан үргэж, дайжихаас сэргийлнэ.	Төслийн талбайн гаднах орон нутгийн зам талбай	Бүртгэл	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Шаарлагатай тохиолдол бүрт	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Шаарлагатай тохиолдол бүрт	
	Нийт						180.0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил нь уул техникийн, инженерийн, хөдөө аж ахуйн болон бусад төрлийн арга хэмжээнүүдээс бүрдэх бөгөөд эдгээр ажлуудын үр дүнд уулын ажлын явцад эвдэрсэн газрын биологийн үр өгөөж сэргээгдэхээс гадна байгаль орчны төлөв байдал анхны хэлбэр унаган төрөхдөө ойртоно.

Уурхайн ашиглалтын явцад уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолгуудыг орчны газрын рельефт нь зохицуулан хэлбэршүүлж, биологийн нөхөн сэргээлт хийж, ургамалжуулах шаардлагатай. Мөн халуун, хүйтэн, ганд тэсвэртэй, нутгийн ургамлын бүрхэвчинд байдаг ургамлаас тариалах нь хөрсний бэхжилтийг дээшлүүлнэ.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь дараах үе шатаар явагдана.

1. Олборлолтод өртөх талбайн үржил шимт өнгөн хөрсийг хуулах, овоолгод хадгалах:

Өлийн голын хэсэгт олборлолтонд өртөх 8.9 га газраас 0.2 м зузаантайгаар шимт хөрсийг хуулна. Энэ нь 17800 м³ шимт хөрс болно. Тухайн хуулсан шимт хөрсийг 5 м өндөртэйгөөр хурааж хадгална.

2. Уул техникийн нөхөн сэргээлт /талбайг тэгшлэх, олборлолтын орон зайг нөхөн дүүргэх, хэлбэршүүлэх, хажууг налуулах болон шимт хөрсөөр хучих зэрэг ажлууд/

- 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд Өлийн голын хэсэгт олборлолтын үйл ажиллагаа явуулахаар тусгагдсан байна. Өлийн голын хэсэгт 7.6 га талбайд нөхөн дүүргэлт хийгдэнэ.
- Өлзийт тээлийн хэсгийн ашиглалтанд өртсөн 12 га талбайд хэлбэржүүлэлтийн ажил хийгдэнэ.
- Хөрсний овоолгыг тэгшлэн налуулж хэлбэршүүлсний дараа бороо хур тунадасны элэгдэл эвдрэлд өртөж болзошгүй хэсгүүдийг чулуу шигтгэж хамгаална.

3. Шимт хөрсийг тараах, шимт хөрсөөр хучих ажил:

Нөхөн сэргээлтийн ажлаар хөрсний овоолго, үйлдвэрийн талбай болон хэвгийжүүлж налуулсан хэсгийг шимт хөрсөөр хучиж ургамалжуулахад бэлэн болгоно. Шимт хөрсийг тарааж хучихдаа 0.2-0.3 м зузаантайгаар бульдозероор тараан байрлуулна.

4. Биологийн нөхөн сэргээлт /Уул техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан газрыг ургамалжуулж ажлыг эхлүүлэх, хөрсийг бордох, сайжруулах, арчлах, тордох талаар тусгагдсан ажлууд хийгдэнэ./

Нөхөн сэргээх ажлын чиг зорилго нь тухайн бүсэд тохирсон ургамалжуулалт бөгөөд биологийн нөхөн сэргээлтийн явцад шимт хөрсөөр хучиж тэгшилсэн талбайд нутгийн өвслөг ургамал болон олон наст ургамал тарьж ургуулах ажлыг хэрэгжүүлнэ. Үүний өмнө техникийн нөхөн сэргээлтээр ургамлаар хучих талбайг сайтар бэлтгэсэн байх нь ургамлын ургалт, өсөлтөнд маш чухал ач холбогдолтой болно.

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6

Зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (сая.төг)		Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт
1. Техникийн нөхөн сэргээлт							
Биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэх	• Шимт хөрс хуулах хадгалах	8.9 га 17.8 мян.м ³	1,500.0	-	Үйлдвэрлэлийн зардалд тусгах	2024	1. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5914-2008 2. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915-2008 3. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хууралт, хадгалалт 4. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5927-2008
	• Олборлолтын орон зайн нөхөн дүүргэлт	7.6 га 865.8 мян.м ³	3,500.0	-			
	• Хэлбэршүүлэх, хажууг налуулах	12 га	1,800.0	-			
	• Шимт хөрсөөр бүрэх	10.0 га	1,200.0	-			
Техникийн нөхөн сэргээлтийн зардлын дүн							
2. Биологийн нөхөн сэргээлт							
Биологийн нөхөн сэргээлт	• Олон наст, нэг наст ургамлын үрийг хольж тариална	4 га	500.0	2.0	Олон наст ургамлын үрийг 2023 онд тариалахад бэлэн болгож нөөцөлсөн.	2024	5. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918-2008
	• Жимсний мод тарих	5 га	400.0	2.0			
Биологийн нөхөн сэргээлтийн зардлын дүн				4.0			
Нийт зардлын дүн				4.0			

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах ажлын гол зорилго нь биологийн төрөл зүйл олон янз байдлыг хамгаалан авч үлдэх, тэдгээрийн амьдран орших нөхцөл байдлыг төсөл хэрэгжих талбайгаас өөр газар, орон зайд бүрэлдүүлэх, биотехникийн арга хэмжээ авах замаар дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөлт, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх явдал юм.

Хүснэгт 7

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жимсний модоор ойн төгөл байгуулах	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	Лицензийн талбайд	3 га	840000.0	2,520.0	Жилийн турш	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5927-2008
2	Зэрлэг амьтдын тоо толгой төрөл зүйлийг нэмэгдүүлэх	Зэрлэг гахай нутагшуулах	Архангай аймаг Цэнхэр сум Орхон баг Таван толгой нэртэй газар	40 ш	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Жилийн турш	Амьтны тухай хууль
3	Зэрлэг амьтдад өвөл, хаврын улиралд өвс тавьж өгөх, хужир мараа тавьж өгөх	Биотехникийн арга хэмжээ	Архангай аймаг Цэнхэр сум Орхон баг Цагдуулт, Таван толгой нэртэй газар	150 боодол өвсийг үе шаттайгаар	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Өвөл, хаврын улиралд	
Нийт		2,520.0						

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн MV-001410 лицензийн талбайд орон нутгийн айлуудын зуслан, өвөлжөө хаваржаа гэх мэт бэлчээрийн болон ахуйн зориулалтаар амьдардаг газар байхгүй тул 2024 онд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох арга хэмжээний ажил төлөвлөгдөөгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Өлзийт тээлийн алтны шороон ордын Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг 2018 онд МУИС, ШУС-ийн Антропологи, археологийн тэнхимтэй хамтран хийлгэсэн бөгөөд Хээрийн судалгаагаар эртний булш, чулуун зэвсгийн болон дундад эртний бууц суурин, хадны сүг зураг бичээс гэх мэт дурсгалын зүйлс илрээгүй. Мөн талбайн дотор ардын зан үйл явуулдаг газар, тахилгат уул овоо байхгүй байгааг судалгааны баг олж тогтоон тайлангаа “БМНС” ХХК-д хүлээлгэн өгсөн.

Мөн 2018 онд ШУА-ийн Палеонтологи, Геологийн хүрээлэнтэй хамтран Палеонтологийн хайгуул судалгааны ажил хийлгэсэн. Тайланд төслийн талбайд тархсан хурдсан палеонтологийн олдвор илрээгүй, сээр нуруутан амьтдын олдвор агуулаагүй манай улсын болон олон улсын хэмээнд давтагдашгүй олдвортой газар биш тул цаашид уул уурхайн үйл ажиллагаа явуулах боломжтой хэмээн дүгнэсэн юм.

Иймд 2024 онд ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-г хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цахилгааны аюулгүй байдал	Нийт ажилчдын цахилгааны аюулгүй байдлын талаархи мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт, зааварчилгаа	Төслийн талбайд	Улирал тутамд	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	ХАБЭА тухай хууль
2	Гал түймэр, галын аюулгүй байдал	Нийт ажилчдын галын аюулгүй байдлын талаархи мэдлэг, мэдээллийг сайжруулах, галын хор хэрхэн зөв ашиглах талаар сургалт, зааварчилгаа	Төслийн талбайд	Улирал тутамд	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	ХАБЭА тухай хууль, Галын Аюулгүй байдлын тухай хууль
3	Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	Одоо ашиглагдаж байгаа үерийн далан шуудуу, хаалт зэргийг шинэчлэн сайжруулах	Төслийн талбайд	Улирал тутамд	Үйл ажиллагааны зардалд туссан	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
4	Тоосжилт, зам тээврийн осол	Төслийн талбайн авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдын хязгаар тогтоож тэмдэг тэмдэглэгээ байршуулах, авто замын усалгааг тогтмол хийх, хэрэгжилтэнд хяналт тавих	Төслийн талбайд	Өдөр тутам	Үйл ажиллагааны зардалд туссан	Үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	Зам тээврийн тухай хууль

5	Болзошгүй осол, эрдлээс сэргийлэх ХАБЭА-н сургалт зааварчилгаа	Нийт ажилчдын ХАБЭА-н хуулийг таниулах сургалт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг сар бүр тогтмол өгөх	Нийт ажилтан, албан хаагчид	Сар бүрийн эхний 5 хоногийн дотор	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд туссан	Жилийн турш	ХАБЭА тухай хууль, Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
---	--	--	-----------------------------	-----------------------------------	--	--	-------------	---

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	Төслийн талбайд	тн	100000.0	8	800.0	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2024 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

2	Үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал	Засвар үйлчилгээ болон төлөвлөгөөт засварын ажлаас гарах шатах тослох материалын сав баглаа боодол, арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Компанийн удирлагын баг, төслийн талбай	Тоо, ширхэг, тн	Үйл ажиллагааны зардал тусгасан	Тухайн үеийн ажлын цар хүрээнээс хамаарч харилцан адилгүй аюултай хог хаягдал гарах тул хэмжих боломжгүй	Үйл ажиллагааны зардал тусгасан	Жилийн турш	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам
3	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ	Байгаль орчны экологич инженер	тн	Хамтран ажиллах байгууллагаас хамааран үнийн дүн өөрчлөгдөж болно	Тээврийн тоо	Үйл ажиллагааны зардал тусгасан	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
5	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ	Байгаль орчны экологич инженер, Архангай аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэнэ.	м.кв	-	Ариутгал халдваргүйтгэл хийсэн талбайн хэмжээ	Үйл ажиллагааны зардал тусгасан	Жилийн турш	
Нийт							500.0		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, Тээврийн хэрэгсэлийн яндангийн утаанд агуулагдах NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох	Уурхайн ажилчдын хотхон, уурхайн дотоод зам, уурхайн каррьер	Жилд 3 удаа	3	150000.0	450.0	Мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
2	Ундны усны эрүүл ахуй, бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	Гал тогооны ундны усны цоргоноос	Улирал тутам	4	50000.0	200.0	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана	Усны тухай хууль, MNS0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
3	Нөхөн сэргээлт хийсэн талбайн ургамалжилт, бэлчээрийн шимт чанарын мониторинг судалгаа	2016-2021 онуудад нөхөн сэргээлт хийсэн талбай	Жилд нэг удаа	3	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Ургамалжилт, шимт чанарын үзүүлэлтийг нөхөн сэргээлт хийсэн оны талбайгаас санамсаргүйгээр мониторингийн цэг сонгож мэдэлэл цуглуулна.	Уул уурхайн үйл ажиллагааны үед эвдрэлд өртсөн газрын нөхөн сэргээх аргачлал 2015


4	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөлнт фосфор, солилцих кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Уурхайн хог хаягдлын цэг орчим, шимт хөрсний овоолго, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	7,9 сард	2	80000.0	160.0	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS(ISO)4814:1999.Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
5	Төслийн талбайг дайран өнгөрч буй амьдарч буй амьтдын тохиолдолын бүртгэл мэдээлэл цуглуулах	Төслийн талбай	Тухай бүрт	-	Үйл ажилагааны зардалд тусгагдсан	Үйл ажилагааны зардалд тусгагдсан	Амьтан мэдээлэл хуудсыг уурхайн нийт ажилчидад таницлах сургалт орох. Амьтан мэдээллэх хуудсын дагуу төслийн талбайд байгаа зэрлэг амьтдын дататай болох	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны арга зүй БОНХЯ.2012
Нийт						810.0		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“БМНС” ХХК нь Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Байгаль орчны экологич 2 инженерийг ажиллуулдаг ба компанийн ерөнхий удирдлагын багийн гишүүд Захирал, Ерөнхий инженер, Уурхайн дарга, Уулын инженерүүд бүх чиглэлээр дэмжин ажиллаж байна.

Хүснэгт 11

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
1	Зэрлэг гахай нутагшуулах	Тодорхойгүй	5 сар	6 сар	7 сар	Компанийн удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	Төслийн бүс нутагт зэрлэг гахай нутагшуулсанаас биологийн төрөл зүйл нэмэгдэж ойн хөрс сайжруулалт сийрүүлэл цаашлаад бичил биетэн өсөж үржих таатай нөхцөл бий болох юм. Мөн хойшид спорт ан агнуурыг тухайн бүс нутагт хөгжүүлж аялал жуулчлалыг хөгжүүлэн орон нутгийн эдийн засагт мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх зорилготой.
2	Зэрлэг гахай нутагшуулахтай холбоотой баримт бичгийн	Тодорхойгүй	5 сар	6 сар	7 сар	Байгаль орчны	Мэргэжлийн байгууллагатай холбоо тогтоож хийгдэж буй

	бүрдүүлэлт хийх					экологич инженер	ажлыг сайжруулах Зэрлэг ан амьтныг хамгаалах тухай Монгол улсын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн ажиллах.
3	Зэрлэг гахай нутагшуулсан тухай өмнөх онуудад хийсэн ажлын үр дүнг олон нийтийн хүртээл болгох	Тодорхойгүй	5 сар	6 сар	7 сар	Компанийн удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр биологийн олон янз байдал, байгаль хамгаалах талаар мэдээлэл хүргэх, орон нутгийн сонин мэдээнд хэвлүүлж иргэдэд тараан харилцан ойлголцох.
4	Нийгмийн хариуцлагын хүрээнд 2016, 2017 онд нөхөн сэргээлт хийсэн талбайг “Малын хүчит тэжээлийн ургамлын фонд”-той болгон эдийн засгийн эргэлтэнд оруулж үр өгөөжөө орон нутгийн иргэдэд өгсөн төслийг хэрэгжүүлэн нутгийн удирдлагад хүлээлгэн өгөх	Тодорхойгүй	5 сар	7 сар	9 сар	Компанийн удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	2021, 2022 оны нөхөн сэргээлт хийсэн талбайг хаалт хашаа хийж малын хүчит тэжээлийн ургамал болох “ЦАРГАС”-г олон наст ургамлуудтай тариалсан бөгөөд энэхүү талбайг эдийн засгийн эргэлтэнд оруулж орон нутагт хүлээлгэн өгсөнөөр орон нутгийн иргэдэд маш олон эерэг үзүүлэлтүүд гарч ирнэ. Үүнд: <ul style="list-style-type: none">  Орон нутгийн иргэд ажлын байртай болох,  Тухайн төсөлд ажиллаж буй орон нутгийн өрхийн орлого нэмэгдэх,

							<ul style="list-style-type: none"> ✚ Бэлчээрийн даацыг сайжруулах, ✚ Тухайн бүс нутгийн малд хүчит тэжээлийн ургамлаар тэжээж үржил шимийг сайжруулах, ✚ Царгасын үрийн нөөцтэй болох, ✚ Царгас өвсний фондтой болох гэх мат маш олон давуу тал бий боолно.
5	Царгас хадах шинэ технологи судалж мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Тодорхойгүй	3 сар	4 сар	5 сар	Байгаль орчны экологич инженер	“Малын хүчит тэжээлийн ургамлын фонд”-той болох төслийн судалгааны ажил.
	Нийт	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН ЗАРДАЛ НЬ ХИЙГДЭХ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭНЭЭС ХАМААРЧ ТУХАЙ БҮРТЭЭ ӨӨРЧЛӨГДӨХ МАГАДЛАЛТАЙ ТУЛ ЗАРДАЛЫН ЗАРЦУУЛАЛТЫГ БҮРТГЭЛЭЭР НЭГТГЭЖ 2024 ОНЫ ТАЙЛАНД ТОВЧ ТОДОРХОЙ ОРУУЛАХ БОЛНО.					

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.	Төслийн талбайд урьж уулзалт зохион байгуулах	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт	2024 оны 9 дүгээр сард	Үйл ажиллагааны зардалд тусгасан	“БМНС” ХХК Удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	Уурхайн кемп
2	Техникийн нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комиссд хүлээлгэн өгөх.	Аймгийн газрын алба, байгаль орчны мэргэжилтэнд газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулна	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	2024 оны 10-р сараас 12-р сарын 1-нд багтаан	Үйл ажиллагааны зардалд тусгасан	“БМНС” ХХК Удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	Төслийн талбай, Нөхөн сэргээлтийн талбай
3	2024 оны БОХМТ-ний хэрэгжилтийн тайлан боловсруулан Архангай аймгийн Байгаль орчны албанд хүргүүлнэ.	Файлаар болон хэвлэмэл хувилбараар	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	2024 оны 11 сарын 1-нд багтаан хүргүүлнэ	Үйл ажиллагааны зардалд тусгасан	“БМНС” ХХК Удирдлагын баг, Байгаль орчны экологич инженер	Архангай аймгийн ЗДТГ
Нийт		БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛЫН ЗАРДАЛ НЬ ХИЙГДЭХ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭНЭЭС ХАМААРЧ ТУХАЙ БҮРТЭЭ ӨӨРЧЛӨГДӨХ МАГАДЛАЛТАЙ ТУЛ ЗАРДАЛЫН ЗАРЦУУЛАЛТЫГ БҮРТГЭЛЭЭР НЭГТГЭЖ 2024 ОНЫ ТАЙЛАНД ТОВЧ ТОДОРХОЙ ОРУУЛАХ БОЛНО.					

15. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын нийт зардлын хэмжээ

Хүснэгт 13

Зардлын төрөл	Нэгж	Утга, мян.төг	Тайлбар
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	мян.төг	2,090.0	Байгаль орчныг хамгаалах ажлын зардалд тусгасан
Нөхөн сэргээлт	мян.төг	4,000.0	Олон наст ургамлын үрийг 2023 онд тариалахад бэлэн болгож нөөцөлсөн.
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	мян.төг	2,500.0	Нөхөн сэргээлтийн ажлын зардалд тусгасан
Хог, хаягдлын менежмент	мян.төг	800.0	Байгаль орчныг хамгаалах ажлын зардалд тусгасан
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	810.0	Байгаль орчныг хамгаалах ажлын зардалд тусгасан
Нийт	мян.төг	10,200.0	